



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 04 сарын 22 өдөр

Дугаар А/262

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 “б”, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Монгол улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2019 оны 05 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын IV.2.6-д батлагдсан “Төрийн байгууллагуудын засвар, тоног төхөөрөмж”-д батлагдсан 300,000,000 (гурван зуун сая) төгрөгөөр хэрэгжих төсөл хөтөлбөр, арга хэмжээний зардлыг хавсралтаар баталсугай.

2. Хавсралтад тусгагдсан хөтөлбөр арга хэмжээг худалдан авах ажиллагааны дагуу зохион байгуулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-д даалгасугай.

3. Шалгарсан аж ахуйн нэгж, байгууллагуудтай гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Г.Баясгалан), аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хөт, байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100577

Аймгийн Засаг даргын 2019 оны 04
дүгээр сарын 22-ны өдрийн 426 дугаар
захирамжийн хавсралт

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГЫН
ТӨСВИЙН БАГЦАД БАТЛАГДСАН ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАД ЭРХ
ШИЛЖСЭН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ИХ ЗАСВАР, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН
ХУВААРИЛАЛТ

№	Төсөл хөтөлбөр, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг /мян төгрөг/
1	Засаг даргын Тамгын газрын барилгын их засвар /Өвөрхангай, Гучин-Ус сум/	20,000.0
2	Засаг даргын Тамгын газрын барилгын их засвар /Өвөрхангай, Өлзийт сум/	30,000.0
3	Засаг даргын Тамгын газрын барилгын их засвар /Өвөрхангай, Баруунбаян-Улаан сум/	41,000.0
4	Засаг даргын Тамгын газрын барилгын их засвар /Өвөрхангай, Бүрд сум/	70,000.0
5	Багийн төвийн барилгын засвар /Өвөрхангай, Хайрхандулаан сум, 5-р баг/	10,000.0
6	Засаг даргын Тамгын газрын барилгын их засвар /Өвөрхангай, Баян-Өндөр сум/	45,000.0
7	Сумдын ИТХурал, ЗДТГ-ын компьютер, тоног төхөөрөмж /Өвөрхангай, 12 сум/	40,000.0
8	Сумдын ИТХурал, ЗДТГ-ын тавилга хэрэгсэл /Өвөрхангай, 12 сум/	44,000.0
	Нийт дүн	300,000.0